

Уул уурхайн сайдын
2013 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн
135 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ГОЕЛОГИ, УУЛ УУРХАЙ САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦ, АЖИЛЛАГЧДЫН НИЙГМИЙН
АСУУДЛЫГШИЙДВЭРЛЭГЧ ТЭРГҮҮНИЙ АЖАХҮЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГА ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл.

- 1.1. Геологи, уул уурхайн салбарын хүний нөөц, ажиллагчдын аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, амьдрах орчин, хүрэлцээтэй цалин хөлс, нийгмийн асуудлыг шийдвэрлэгч тэргүүний аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.
- 1.2. Энэхүү журмын зорилго нь геологи хайгуулын судалгаа, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын нийгмийн асуудлыг хууль, эрх зүй, эрүүл ахуй болон аюулгүй ажиллагааны стандарт, шаардлагын дагуу бүрдүүлж хангуулах үйл ажиллагааг урамшуулан дэмжихэд оршино.
- 1.3. Шилдэг аж ахуйн нэгжийн шалгаруулалтад Монгол Улсын нутаг дэвсгэрт геологи хайгуулын судалгаа, уул уурхайн олборлох, баяжуулах, боловсруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагууд хамрагдана.
- 1.4. Шилдэг аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах ажлыг Уул уурхайн сайдын тушаалаар баталсан ажлын хэсэг удирдан зохион байгуулж, санал, дүгнэлт, холбогдох баримт бичгийг сайдад танилцуулан шийдвэр гаргуулна.
- 1.5. Тэргүүний аж ахуйн нэгжийг шалгаруулах ажлын хэсгийг Уул уурхайн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Уул уурхайн бодлогын хэлтэс ахлана.
- 1.6. Шилдэг аж ахуйн нэгжээр шалгарсан байгууллагад Уул уурхайн сайдын гарын үсэгтэй батламж, дурсгалын зүйл хадгалуулна.
- 1.7. Болзол хангасан аж ахуйн нэгжийг “Ажлын байр, амьдрах ая тухтай орчин бүрдүүлэгч шилдэг аж ахуйн нэгж, байгууллага”, “Ажилчдын эрүүл чанартай хүнс, эрүүл ахуйг эрхэмлэгч аж ахуйн нэгж, байгууллага” “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг эрхэмлэгч аж ахуйн нэгж, байгууллага” зэрэг номинацуудаас тус бүр 1 аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулна.

Хоёр. Шалгаруулах үзүүлэлт.

2.1. Ажлын байр, амьдрах ая тухтай орчин бүрдүүлэгч шилдэг аж ахуйн нэгж, байгууллага шалгаруулах болзол:

- 2.1.1 Уурхайн тосгон, ажилчдыг ая тухтай ажлын болон амрах байраар хангасан байдал;
- 2.1.2 Олборлох салбарын ил тод байдлын санаачлагад нэгдэн жил бүрийн тайлангаа гаргаж өгсөн байдал;
- 2.1.3 Ашиглаж байгаа ордын дэд бүтэц, уурхайн тосгон, барилга байгууламжийн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байдал;
- 2.1.4 Мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх болон ажилтаныг мэргэшүүлэх, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангасан байдал;
- 2.1.5 Тухайн орон нутагаас бүрдүүлж буй ажлын байр, нийт ажилчдын цалин, урамшууллыг тогтоосон байдал.

2.2. Ажилчдын эрүүл ахуйг эрхэмлэгч шилдэг аж ахуйн нэгж, байгууллага шалгаруулах болзол:

- 2.2.1 Уурхай, олборлох үйлдвэр, уурхайн тосгонд эмч, сувилагч болон эмнэлгийн тоног төхөөрөмж, эмчилгээний байраар бүрэн хангагдсан байдал;
- 2.2.2 Хүнд, хортой нөхцөлд ажиллагсдын эрүүл мэнд, сувилгааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэн байдал;
- 2.2.3 Ажиллагчдын бие, бялдарыг чийрэгжүүлэх төв байгуулсан байдал;
- 2.2.4 Эрүүл мэндийн үзлэгт хамруулах төлөвлөгөө, хуваарийн дагуу ажилласан байдал;
- 2.2.5 Чөлөөт цагийг зөв, боловсон өнгөрүүлэх нөхцөл бүрдүүлсэн байдал;
- 2.2.6 Эрүүл, чанартай хоол хүнсээр хангасан байдал;

2.3. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг эрхэмлэгч аж ахуйн нэгж, байгууллага шалгаруулах болзол:

- 2.3.1 Үйлдвэрлэлийн жигд, найдвартай ажиллагаа, аваар, осолгүй ажилласан цаг, төлөвлөгөөт зорилтын биелэлт;
- 2.3.2 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг сайжруулах ажилд төлөвлөсөн ба зарцуулсан хөрөнгө, зардал;
- 2.3.3 Ажилчдын амралтын байр, ая тухтай орчин тохилог байдал, нийгмийн асуудлыг шийдсэн байдал;
- 2.3.4 Мэргэжлийн, мэргэшлийн сургалтын материаллаг баазаар хангагдсан байдал;
- 2.3.5 Үйлдвэрлэлийн ослын болон ослоос шалтгаалсан нас бааралтын давтамжийн коэффициент салбарын дунджаас бага байх, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлт өмнөх жилүүдийнхээс буурсан байх;

Гурав. Бүрдүүлж ирүүлэх материал.

3.1. Шалгаруулалтад оролцохыг хүссэн аж ахуйн, нэгж байгууллага албан бичгээр хүсэлтээ гарган, шаардлагатай материал, холбогдох бусад материал, зургыг Ашигт малтмалын газарт Ажлын хэсгээс тогтоосон хугацаанд ирүүлнэ.